



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/315

Булган сум

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй
нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд уул уурхайн ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын хүрээнд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн
хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбар хяналт,
зохицуулалтын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн
хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Байгаль
орчин, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Дээрх ажлыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, хяналт тавьж хэрэгжилтийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хуралд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010444